

Компаний удирдлага

Зарим компаниудыг зарим компаний хамтарсан эзэмшигчид гэж үздэг. Учир нь уг кодпаниуд нь тэдгээр компаниудын хувьцааны хэсгийг эзэмшдэг. Жишээ нь Форд Маздагийн 12%-г эзэмшдэг. Хэрвээ дараах нөхцлүүдийн дор хаяж нэг нь биелж байвал А компани В компанийг удирддаг гэж үзнэ.

- А Компани = В Компани
- А компани В компаний 50%-иас илүү хувийг эзэмшдэг.
- А компани C_1, \dots, C_K гэсэн К компанийг удирддаг, эдгээр C_i компани бүр В компаний x_i хувийг эзэмшдэг бөгөөд $x_1 + \dots + x_K > 50\%$.

(i,j,p) жагсаалт өгөгдсөн бөгөөд энэ нь i компани p компаний j хувийг эзэмшдэг гэсэн үг. Бүх (h,s) хосыг ол. Энд h компани s компанийг удирддаг гэсэн үг. Хамгийн ихдээ 100 компани байгаа. i, j, p нь эерэг бүхэл тоо бөгөөд бүгд 1-100 хооронд байна. (i,j,p) гурвалсан хосын дарааллыг уншиж h компани s компанийг удирдана гэдгийг илэрхийлэх бүх (h,s) хосуудыг олох програм бич.

Програмын нэр: `concom`

Оролтын формат

1-р мөр: n эерэг бүхэл тоо, нийт хэдэн мөр гурвалсан хос уншихыг заана.

2-р мөр: Зайгаар тусгаарлагдсан 3 бүхэл тоо i,j,p .

Жишээ оролт (файл `concom.in`)

```
3
1 2 80
2 3 80
3 1 20
```

Гаралтын формат

0 буюу түүнээс их (h,s) хосыг хэвлэ. Эхний бүхэл тоогоор нь эрэмблэн харуул. Компани өөрөө өөрийгөө удирдана гэдгийг хэвлэхгүй.

Жишээ гаралт (файл `concom.out`)

```
1 2
1 3
2 3
```

Орчуулсан Б.Даваабаяр